“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн
хамт олны хурлын 01 тоот шийдвэрийн Хавсралт 1.

# “МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК-ИЙН АЖИЛЛАГСДЫН ХУРИМТЛАЛЫН САН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ТАЙЛАГНАХ ТУХАЙ ЖУРАМ

## *Нэг. Нийтлэг үндэслэл*

Журмын гол зорилго нь “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК /цаашид “Компани” гэх/-ийн хамт олон, ажилтанд баяр, ёслол, хүнд хэцүү үе тохиоход хамтдаа бие биеэ дэмжин сэтгэл санааны болон эд хөрөнгийн дэм үзүүлэх зорилгоор сар бүр мөнгөн хуримтлал үүсгэн, түүнийг зарцуулах, тайлагнах харилцааг зохицуулна.

## *Хоер. Хуримтлалын сан бүрдүүлэлт*

2.1. Хуримтлалын сан /цаашид “Сан” гэх/-ийн орлого бүрдүүлэлтийг дараах эх үүсвэрээр хангана. Үүнд:

2.1.1. Компанийн ажилтан тус бүр сар тутам 20 000 /хорин мянга/ төгрөгийг Богд банкны 8100002262 тоот данс руу шилжүүлнэ.

2.1.2. Гадаадад томилолтоор ажиллаж/ сурч буй ажилтнууд Санд өөрийн сайн дураар хүссэн хэмжээгээр мөнгө хандивлаж болно.

2.1.3. Өндөр хэмжээний шагнал урамшуулал авсан ажилтан Санд өөрийн сайн дураар хүссэн хэмжээгээр мөнгө хандивлаж болно.

## *Гурав. Сангийн зарцуулалтын зориулалт, хэмжээ*

3.1. Сангийн хөрөнгийг хамтын шийдвэрээр дараах тохиолдолд зарцуулна. Үүнд:

| № | Зарцуулалтын зориулалт | Зарцуулалтын хэмжээ /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Ажилтан гэр бүл болж, гэрлэлтээ батлуулсан | 500,000 |
| 2 | Ажилтан болон ажилтны эхнэр амаржсан, хүүхэд үрчлэн авсан | 500,000 |
| 3 | Ажилтан төр, засгийн дээд шагнал одонгоор шагнуулсан | 300,000 |
| 4 | Төрсөн өдрийн бэлэг, 1 хүнд | 50,000 |
| 5 | Ажилтан гавьяаны амралт авах, | 300,000 хүртэл |
| 6 | Ажилтны орон байр, ахуйн зүйлс гамшиг, осолд нэрвэгдэх, халдлагад өртөх | 500,000 хүртэл |
| 7 | Ажилтан нас барах | 2,000,000 |
| 8 | Гэр бүлийн гишүүд нас барах /төрсөн аав, ээж, ах, эгч, дүү, эхнэр, нөхөр, үр хүүхэд, өвөө, эмээ/ | 500 000 |
| 9 | Ажилтан хүнд өвчний улмаас эмчилгээнд хамрагдах | 500,000 |
| 10 | Байгууллагын уралдаан тэмцээн, соёл урлагийн нэгдсэн арга хэмжээ | 1,000,000 хүртэл<br>Тухай бүрт тооцоо гаргаж байх |

***Дөрөв. Сангийн удирдлага, тайлан, мэдээ гаргах***

4.1. Хамт олны хурлаас сонгогдсон 5 /тав/ гишүүний бүрэлдэхүүнтэй Зөвлөл Сангийн үйл ажиллагааг хариуцан ажиллана. Зөвлөлийн 2 гишүүний нэгдүгээр гарын үсэг бүхий дансыг нээж хуримтлалыг бий болгоно.

4.2. Зөвлөл Сангийн орлого, зарлага, үлдэгдлийн мэдээг сар бүр гарган нийт ажилтнуудад цахим шуудангаар илгээн, мэдээлж, жилийн тайланг хамт олны хурлаар танилцуулж батлуулна.

4.3. Ажилтнуудаас Сангийн хуримтлал бүрдүүлэлтийн мөнгөний хэмжээ болон Сангаас зарцуулалт хийх үйл ажиллагаанд зориулах мөнгөний хэмжээ, зориулалт нөхцөл байдлын талаар гаргасан саналыг Зөвлөлөөр хэлэлцэн, шийдвэрлэж мэдээлнэ.

-----o O o-----

## “МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК-ИЙН ХАМТ ОЛНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

**№01**

2020-10-26

Хурал 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 11:00 цагт компанийн хурлын танхимд болов.

Хурлыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Х.Оюунцэцэг даргалж, компанийн нийт ажилтнууд оролцов.

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн ажиллагсдын хуримтлалын сан байгуулах тухай
2. ““Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн ажиллагсдын хуримтлалын сан бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнах журам” батлах тухай
3. “Сан”-ийн үйл ажиллагааг хариуцан ажиллах Зөвлөл байгуулах тухай

**Хэлэлцсэн нь:**

Х.Оюунцэцэг: Компанийн ажиллагсад, хамт олон, хувь хүнд баяр, ёслол, хүнд хэцүү үе тохиоход хамтдаа бие биеэ дэмжин сэтгэл санааны болон эд хөрөнгийн дэм үзүүлэх зорилгоор сар бүр мөнгөн хуримтлал үүсгэн, түүнийг зарцуулах, тайлагнах ““Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн ажиллагсдын хуримтлалын сан бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнах журам”-ын төслийг Судалгаа, хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Ш.Мөнхцэцэг боловсруулсан. Үүнийг та бүхэнд танилцуулъя.

Журмын төслийг мэргэжилтэн Ш.Мөнхцэцэг нийт ажилтнуудад уншиж танилцуулав.

Х.Оюунцэцэг: Хамт олон та бүхэн энэхүү журамд нэмж оруулах болон санал болгох зүйл байна уу? Мөн “Сан”-ийн үйл ажиллагааг 5 /тав/ хүний бүрэлдэхүүнтэй Зөвлөл хариуцан ажиллана. Зөвлөлийн гишүүдэд дараахь хүмүүсийн бүрэлдэхүүнтэй байгуулах санал гаргаж байна. Үүнд:

1. Л.Нямчулуун /Дотоод хяналтын албаны мэргэжилтэн/
2. Н.Ундармаа /Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн/
3. Ш.Мөнхцэцэг /Судалгаа, хөгжлийн мэргэжилтэн/,
4. Ч.Номуунзаяа Шугам хоолойн инженер
5. С.Батцэцэг Хүний нөөцийн мэргэжилтэн

Журам болон Сангийн үйл ажиллагааг хариуцан ажиллах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлахыг зөвшөөрч байвал санал аа өгнө үү. Хамт олны 100 хувийн саналаар ""Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн ажиллагсдын хуримтлалын сан бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнах журам" болон Зөвлөлийн бүрэлдэхүүн батлагдав.

Х.Оюунцэцэг: Журмын төсөлд цахимаар санал авч эцсийн найруулгыг боловсруулан энэхүү тэмдэглэлд хавсаргана. Журмыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлнэ. Богд банкинд данс нээж дараах 2 ажилтанд 1 дүгээр гарын үсгийн баталгаажуулалт хийж мөнгийг зарцуулах саналтай байна Үүнд:

- С.Батцэцэг
- Ч.Номуунзаяа

Хамт олны зүгээс нэмж оруулах, санал болгох зүйл байхгүй тул дараах байдлаар

**Шийдвэрлэсэн нь:**

1. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн ажиллагсдын хуримтлалын сан байгуулж, сар бүрийн 30/31-ний дотор ажилтан тус бүр 20 000 /хорин мянган/ төгрөг шилжүүлэх;
2. ""Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн ажиллагсдын хуримтлалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнах журам"-ыг Хавсралт 1-ээр батлах,
3. Нийт ажилтнуудад танилцуулж, гарын үсэг зуруулсан нэрсийн жагсаалтыг Хавсралт 2-оор хурлын тэмдэглэлд хавсаргах;
4. "Сан"-ийн үйл ажиллагааг хариуцан ажиллах Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг баталж, мөнгөн хуримтлалын данс нээж, захиран зарцуулах эрхийг С.Батцэцэг, Ч.Номуунзаяа нарт олгох;

Хурал 12:40 цагт өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн: Ш.Мөнхцэцэг

**“МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК-ИЙН 2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙН ХАМТ ОЛНЫ ХУРЛЫН ШИЙДВЭРТЭЙ ТАНИЛЦСАН АЖИЛЛАГСДЫН НЭРС, АЛБАН ТУШААЛ, ГАЗРЫН ҮСЭГ**

| № | Ажиллагсдын нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | Д.Алтанцэцэг | Гүйцэтгэх захирал | |
| 3 | Х.Оюунцэцэг | Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга | |
| 4 | С.Батцэцэг | Гадаад ажиллагсдын асуудал хариуцсан мэргэжилтэн | |
| 5 | С.Банзрагч | Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | |
| 6 | Б.Ууганбаяр | Жолооч | |
| 7 | Б.Өнөрбат | Жолооч | |
| 8 | У.Чинзориг | Хууль, гэрээ эрх зүйн хэлтсийн дарга | |
| 9 | Ч.Оргил | Гэрээ хариуцсан мэргэжилтэн | |
| 10 | С.Сарангоо | Гэрээ хариуцсан мэргэжилтэн | |
| 11 | Ц.Оюунсүрэн | Архив, нууц хамгаалах ажилтан | |
| 12 | Т.Төгсбаяр | Байгаль орчин, хөдөлмөр хамгааллын хэлтсийн дарга | |
| 13 | Х.Булган | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн | |
| 14 | П.Саруул | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн | |
| 15 | Н.Ундармаа | Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн | |
| 16 | Б.Чинтуяа | Санхүү, эдийн засгийн газрын дарга | |
| 17 | Б.Баярмаа | Нягтлан бодогч | |
| 18 | Я.Энхбат | Гааль, татвар хариуцсан мэргэжилтэн | |
| 19 | Н.Батцэнгэл | Төсөвчин | |
| 20 | О.Түмэн-Өлзий | Түүхий эдийн хангамж хариуцсан ахлах мэргэжилтэн | |
| 21 | Д.Дэмбэрэлням | Түүхий эдийн хангамж хариуцсан мэргэжилтэн | |
| 22 | Г.Уламбаяр | Дамжуулах хоолойн инженер | |
| 23 | Б.Эрдэнэбат | Механик инженер | |
| 24 | Б.Сайнбаяр | Дулааны инженер | |
| 25 | Б.Мэнд-Уянга | Дамжуулах хоолойн инженер | |
| 26 | Г.Түмэнгэрэл | Дамжуулах хоолойн техникч | |
| 27 | О.Энхбаяр | Дотоод хяналтын газрын дарга | |
| 28 | Л.Нямчулуун | Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн | |
| 29 | Б.Бадамгарав | Санхүүгийн аудиторч | |
| 30 | А.Баяржаргал | Барилга төлөвлөлт, угсралтын инженерийн албаны дарга | |
| 31 | Б.Оргилболд | Барилгын инженер | |
| 31 | Г.Болорчулуун | Агуулах сав, парк хариуцсан инженер | |
| 33 | Э.Буянбаатар | Үйлдвэрийн шугам хоолойн инженер | |
| 34 | Ч.Номуунзаяа | Үйлдвэрийн шугам хоолойн инженер | |
| 35 | Г.Тулга | Цахилгааны инженер | |

| | | | |
|---|---|---|---|
| 36 | Бямба.Төгөлдөр | Сантехникийн инженер | |
| 37 | Б.Энхбат | Барилгын хяналтын инженерийн алба | |
| 38 | Б.Батхишиг | Барилгын инженер | |
| 39 | М.Отгонсүрэн | Үйлдвэрийн талбай хариуцсан мэргэжилтэн | |
| 40 | С.Жавзандулам | Материалын инженер | |
| 41 | Б.Юра | Дохиолол холбооны инженер | |
| 42 | Б.Мөнх-Эрдэнэ | Процессийн инженерийн албаны дарга | |
| 43 | П.Анударь | Технологич-инженер, инженерчлэл хариуцсан зохицуулагч | |
| 44 | Т.Тулга-Очир | Нефть химийн инженер | |
| 45 | Н.Ууганбаяр | Нефть химийн инженер | |
| 46 | Б.Энхтөр | Автоматжуулалт, тоног төхөөрөмжийн инженер | |
| 47 | Б.Төгөлдөр | Автоматжуулалт, тоног төхөөрөмжийн инженер | |
| 48 | Н.Нямпүрэв | Дулааны инженер | |
| 49 | Б.Энхзаяа | Процессийн аюулгүй ажиллагааны инженер | |
| 50 | Б.Энхжаргал | Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны инженер | |
| 51 | М.Дашцэдэн | Цахилгааны инженер | |
| 52 | Л.Орхон | Процессийн инженер | |
| 53 | Т.Пэрэнлиймаа | Процессийн инженер | |
| 54 | Б.Мөнх-Эрдэнэ | Процессийн инженер | |
| 55 | С.Буяндалай | Дэд бүтцийн инженерийн албаны дарга | |
| 56 | Т.Гандэлгэр | Дэд бүтэц хариуцсан инженер | |
| 57 | Д.Бадарч | Эрчим хүчний хяналтын инженер | |
| 58 | Д.Баяраа | Төмөр замын хяналтын инженер | |
| 59 | П.Шагай | Програм хангамж хариуцсан мэргэжилтэн | |
| 60 | Э.Анхбаяр | Системийн удирдлага хариуцсан мэргэжилтэн | |
| 61 | Б.Түвшинбат | Мэдээлэл харилцааны хэлтсийн дарга | |
| 62 | М.Очбаяр | Мэдээлэл технологийн мэргэжилтэн | |
| 63 | Т.Үүрцайх | Хэвлэл, олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн | |
| 64 | Н.Дүгэрсүрэн | Судалгаа, хөгжлийн хэлтсийн дарга | |
| 65 | Ш.Мөнхцэцэг | Судалгаа, хөгжлийн мэргэжилтэн | |
| 66 | Э.Мөнхбаяр | Судалгаа, хөгжлийн мэргэжилтэн | |
| 67 | Т.Эрдэнэбат | Тээвэр хариуцсан мэргэжилтэн | |
| 68 | О.Болдбаяр | Ложистик хариуцсан мэргэжилтэн | |

-----o O o-----